

“Очир ундраа ОМЗ” ХХК-д банк бус санхүүгийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.3.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.1 дэх хэсэг, “Очир ундраа ОМЗ” ХХК-ийн хувь нийлүүлэгчийн 2008 оны 01 тоот шийдвэрийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Очир ундраа ОМЗ” ХХК-д Улаанбаатар хотод зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2.Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Очир ундраа ОМЗ” ББСБ /Т.Гантөмөр/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолыг олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Ж.Жадамбаа/, “Очир ундраа ОМЗ” ББСБ-ын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Банк бус санхүүгийн байгууллагын газар /Х.Бум-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ